

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК
аудитор: С.Цэрэнминжин
Утас: 89982722 Цахим хаяг: tseren8153@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
5.1 Залруулсан алдаа.....	
5.2 Төлбөрийн акт	
5.3 Албан шаардлага.....	
5.4 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН 1-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ТУНГАЛАГ ТАНАА

2022.02.24 № УВА-2022/107/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол улсын Засгийн газрын 5 дугаар тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 4/430 дугаар тушаалын хүрээнд цэцэрлэгийн багш, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдаж 5 багш 1-р түвшинд, 1 багш 2-р түвшин, 1 багш 3-р түвшинд, байгууллагын хэмжээнд 1-р түвшинд үнэлэгдэж, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 сарын 29-ний өдрийн А/500 дугаар тушаалаар гүйцэтгэл чанар, үр дүнг үнэлж урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200475

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>70,452,064.52</u>	<u>95,387,773.81</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	20,206,660.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	20,206,660.23
3121	Төгрөг	00.00	20,206,660.23
31211	Төрийн сангийн харилцах	00.00	20,206,660.23
33	АВЛАГА	14,100,000.00	4,797,399.06
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	100,000.00	1,200,000.00
335	Бусад авлага	14,000,000.00	3,597,399.06
3351	Байгууллагаас авах авлага	14,000,000.00	3,597,399.06
35	БАРАА МАТЕРИАЛ	56,352,064.52	70,383,714.52
354	Хангамжийн материал	56,352,064.52	70,383,714.52
35460	Хүнсний материал	3,343,800.00	1,661,150.00
35470	Бусад хангамжийн материал	52,048,264.52	68,722,564.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>817,610,724.43</u>	<u>794,767,555.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	817,610,724.43	794,767,555.17
392	Биет хөрөнгө	717,350,724.43	694,507,555.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	716,482,266.87	716,482,266.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	-48,193,203.97	-64,150,385.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,882,962.00	78,194,810.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-59,139,097.66	-52,625,640.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,282,604.60	33,655,904.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,569,352.29	-25,876,484.61
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,705,000.00	20,705,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,503,815.12	-16,341,276.38
39217	Ном	4,403,360.00	4,463,360.00
393	Биет бус хөрөнгө	100,260,000.00	100,260,000.00
39301	Програм хангамж	935,000.00	935,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-935,000.00	-935,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	100,260,000.00	100,260,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>888,062,788.95</u>	<u>890,155,328.98</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>888,062,788.95</u>	<u>890,155,328.98</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	888,062,788.95	890,155,328.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	366,100,395.91	366,100,395.91
51101	Өмч: - төрийн	366,100,395.91	366,100,395.91
512	Хуримтлагдсан үр дүн	21,075,995.93	23,168,535.96
51210	Өмнөх үеийн үр дүн	21,075,995.93	21,075,995.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,092,540.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	500,886,397.11	500,886,397.11

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	888,062,788.95	890,155,328.98
---	--	-----------------------	-----------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	504,300,486.57	594,824,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	504,070,486.57	561,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	238,138.24	561,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	238,138.24	561,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	238,138.24	561,400.00
122	Тусламжийн орлого	55,927,548.33	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	55,927,548.33	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	447,904,800.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	447,904,800.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,000.00	594,262,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	512,642,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	512,642,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	230,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	81,620,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	81,620,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	501,859,863.62	592,511,313.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,859,863.62	592,511,313.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,988,156.43	573,141,413.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,022,836.85	379,235,127.94
210101	Үндсэн цалин	268,387,920.61	256,671,592.94
210102	Нэмэгдэл	38,249,825.00	85,364,994.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,495,501.00
210104	Урамшуулал	28,385,091.24	35,703,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,678,832.96	48,604,952.77
210201	Тэтгэврийн даатгал	29,812,334.17	34,327,220.07
210202	Тэтгэмжийн даатгал	3,231,043.42	3,311,257.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,725,718.08	3,188,352.28
210204	Ажилгүйдлийн даатгал	628,022.32	832,507.85
210205	Эрүүл мэндийн даатгал	6,281,714.97	6,945,614.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,240,448.33	50,342,030.04
210301	Гэрэл, цахилгаан	1,678,066.33	2,774,099.04
210302	Түлш, халаалт	44,684,051.00	43,796,151.00
210303	Цэвэр, бохир ус	3,878,331.00	3,771,780.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,343,683.24	5,775,850.00
210401	Бичиг хэрэг	1,921,988.24	1,970,800.00
210402	Тээвэр, шатахуун	136,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,700.00	00.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,009,600.00	2,561,050.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	105,600.00	960,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	284,000.00
2105	Нормативт зардал	15,448,820.00	48,120,680.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	476,500.00	51,900.00
210502	Хоол, хүнс	14,972,320.00	48,068,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,800,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	5,800,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,462,000.00	732,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	730,000.00	732,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,991,535.05	38,329,872.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,796,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,284,650.00	2,631,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,706,885.05	30,902,722.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,871,707.19	19,369,899.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	779,042.00	17,283,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	779,042.00	17,283,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,092,665.19	2,086,399.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,092,665.19	2,086,399.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,440,622.95	2,312,686.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	220,146.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	220,146.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-220,146.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,440,622.95	2,092,540.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	504,062,348.33	594,262,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	503,832,348.33	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	503,832,348.33	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	447,904,800.00	00.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	55,927,548.33	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,000.00	594,262,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	512,642,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	512,642,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	230,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	81,620,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	81,620,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	504,062,348.33	574,055,939.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	504,062,348.33	574,055,939.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493,190,641.14	554,686,039.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	333,976,844.85	385,103,225.34
210101	Үндсэн цалин	262,730,406.61	256,988,045.34
210102	Нэмэгдэл	41,091,101.00	90,547,994.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,555,501.00
210104	Урамшуулал	30,155,337.24	36,011,685.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,678,832.96	47,434,254.43
210201	Тэтгэврийн даатгал	30,301,378.46	29,073,386.36
210202	Тэтгэмжийн даатгал	3,206,499.82	7,672,395.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,727,683.40	2,976,571.91
210204	Ажилгүйдлийн даатгал	625,498.62	809,537.90
210205	Эрүүл мэндийн даатгал	5,817,772.66	6,902,362.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,127,548.33	50,342,030.04
210301	Гэрэл, цахилгаан	1,678,066.33	2,774,099.04
210302	Түлш, халаалт	44,516,151.00	43,796,151.00
210303	Цэвэр, бохир ус	3,933,331.00	3,771,780.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,365,995.00	00.00
210401	Бичиг хэрэг	461,600.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	303,900.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,700.00	00.00
210404	Ном, хэвлэл	394,800.00	00.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,529,995.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,395,000.00	00.00
2105	Нормативт зардал	19,542,620.00	46,386,130.00
210502	Хоол, хүнс	18,108,120.00	46,386,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,529,900.00	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	00.00
210602	Тавилга	729,900.00	00.00
210604	Урсгал засвар	5,800,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,462,000.00	732,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	730,000.00	732,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,506,900.00	22,687,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,932,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,506,900.00	3,754,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,871,707.19	19,369,899.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	779,042.00	17,283,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	779,042.00	17,283,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,092,665.19	2,086,399.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,092,665.19	2,086,399.96
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	20,206,660.23
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	20,206,660.23
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	20,206,660.23

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлаг дсан дүн	/төгрөг/	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	265,840,395.91	222,367,115.46	32,821,944.68	00.00	521,029,456.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,840,395.91	222,367,115.46	32,821,944.68	00.00	521,029,456.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00

C07	Тайлант үеийн үр дүн	100,260,000.00	00.00	19,698,114.65	00.00	119,958,114.65
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,100,395.91	500,886,397.11	21,075,995.93	00.00	888,062,788.95
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	366,100,395.91	500,886,397.11	21,075,995.93	00.00	888,062,788.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,100,395.91	500,886,397.11	21,075,995.93	00.00	888,062,788.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,092,540.03	00.00	2,092,540.03
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,100,395.91	500,886,397.11	23,168,535.96	00.00	890,155,328.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	594,262,600.00	574,055,939.77	-20,206,660.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594,262,600.00	574,055,939.77	-20,206,660.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	576,979,100.00	554,686,039.81	-22,293,060.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	388,427,200.00	385,103,225.34	-3,323,974.66
210101	Үндсэн цалин	313,959,500.00	256,988,045.34	-56,971,454.66
210102	Нэмэгдэл	58,113,200.00	90,547,994.00	32,434,794.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,555,501.00	1,555,501.00
210104	Урамшуулал	16,354,500.00	36,011,685.00	19,657,185.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,190,500.00	47,434,254.43	-1,756,245.57
210201	Тэтгэврийн даатгал	33,554,900.00	29,073,386.36	-4,481,513.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,925,900.00	7,672,395.91	3,746,495.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,140,800.00	2,976,571.91	-164,228.09
210204	Ажилгүйдлийн даатгал	775,000.00	809,537.90	34,537.90
210205	Эрүүл мэндийн даатгал	7,793,900.00	6,902,362.35	-891,537.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,428,100.00	50,342,030.04	-2,086,069.96
210301	Гэрэл, цахилгаан	4,067,400.00	2,774,099.04	-1,293,300.96
210302	Түлш, халаалт	44,446,100.00	43,796,151.00	-649,949.00
210303	Цэвэр, бохир ус	3,914,600.00	3,771,780.00	-142,820.00
2105	Нормативт зардал	61,086,800.00	46,386,130.00	-14,700,670.00
210502	Хоол, хүнс	61,086,800.00	46,386,130.00	-14,700,670.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00	00.00

210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	732,900.00	-229,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	732,900.00	-229,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22884500.00	22687500.00	-197,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,104,500.00	18,932,550.00	-171,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,780,000.00	3,754,950.00	-25,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17283500.00	17283500.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,283,500.00	17,283,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,283,500.00	17,283,500.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	594,262,600.00	594,262,600.00	00.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	512,642,400.00	512,642,400.00	00.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	512,642,400.00	512,642,400.00	00.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,620,200.00	81,620,200.00	00.00
132001	Орон нутгийн төсвөөс	81,620,200.00	81,620,200.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	20,206,660.23	20,206,660.23
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	24.00	-06.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	00.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	06.00	-06.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын 1-р цэцэрлэг нь багш ажилчдын чадавхыг дээшлүүлж сургалтандаа орчин үеийн техник технологийн дэвшлийг өргөн нэвтрүүлж, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжиж, хүүхэд хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Үүнд:

- ✓ Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 2008 оны 05 дугаар сарын 08-ны өдөр батлагдаж 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон байна.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр

- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,093.0 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	20.206.7	20.206.7
Авлага	14.100.0	4.797.4	-9.303.0
Бараа материал	56.352.1	70.383.7	14.032.0
Үндсэн хөрөнгө	817.610.7	794.767.6	-22.843.0
Нийт хөрөнгө	888.062.8	890.155.3	2.093.0
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	888.062.8	890.155.3	2.093.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	888.062.8	890.155.3	2.093.0

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь 2022 онд 20,206.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны эхний үлдэгдэл нь 14,100.0 мянган төгрөг тайлант онд бүрэн барагдаж, 4,797.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага үүссэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 70,383.7 мянган төгрөг болж 14,032.0 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал өссөнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 794,767.6 мянган төгрөг болж, 22,843.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь 14,247.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 4,286.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил актласантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 890,155.3 мянган төгрөг болж 2,093.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн нь 890.155.3 мянган төгрөг болж өмнөх оны үр дүнгээс 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 594,262.6 мянган төгрөгөөр тооцон төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төсөлд өөрчлөлт оруулахгүйгээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 594.262.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 512,642.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 81,620.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 512,642.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 81,620.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвийн 492,435.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвийн дансанд 20,206.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвөөс 79,533.8 мянган төгрөгийг зарцуулж 2,086.4 төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Улсын төсвөөс санхүүжих	512,642,4	492,435,7	20,206,7	96,1%
2	Орон нутгийн төсвөөс санхүүжих	81,620,2	79,533,8	2,086,4	97,4%

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 492,435.7 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 3,323.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,756.2 мянга, хүүхдийн хоолны зардлыг 14,700.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 197.0 мянга, гэрэл цахилгаан зардлыг 1,293,3 мянга, цэвэр бохир ус 142,8 мянга, түлш халаалтын зардлыг 649,9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Улаангом сумын 1-р цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаангом сумын 1-р цэцэрлэг нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор С.Цэрэнминжин гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 501.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 576.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Улаангом сумын 1-р цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаангом сумын 1-р цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“УВС ФИНАНС АУДИТ” ХХК-ийн
АУДИТОР 

/С.ЦЭРЭНМИНЖИН/

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр